



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ


Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/166/НА-СТА-ТШЗ





ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.02.21

№

29

танай _____ -ны № _____ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЕСӨНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ХОЁРДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Э.ТЭРБИШ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Орон нутгийн төсвөөс 50,800.0 мянган төгрөгийн их засварын ажлыг санхүүжүүлсэн байна.

Монголын цахилгаан холбоо ХХК-аас 51,879.0 мянган төгрөгөөр утасгүй дотоод сүлжээ байгуулах ажил хийгдэж, үлдэгдэл төлбөр болох 6,075.0 мянган төгрөгийг ирэх онд төлөхөөр гэрээнд тусгаснаас шалтгаалан өр үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8225020077

Тайлант онд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын А/80 дугаар тушаалын дагуу математик, англи хэлний цахим сургалтын хөтөлбөр хэрэгжиж гэрээний дагуу патентын эрхийн төлбөр болох 10,473.6 мянган төгрөгийг олгож шууд зардлаар тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын төсөв захирагч 1 зорилго 5 зорилт хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, аймгийн Боловсролын газраас биелэлтийг 87 хувь гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	267,066.8	289,905.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,670,754.7	3,548,340.7
Нийт хөрөнгийн дүн	3,937,821.6	3,838,245.8
Нийт өр төлбөрийн дүн	41,491.2	6,075.1
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,896,330.4	3,832,170.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,937,821.6	3,838,245.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	3,033,903.7	3,008,976.0
Үйл ажиллагааны зардлын дүн	2,364,863.4	3,066,827.2
Үйл ажиллагааны үр дүн	669,040.3	(57,851.1)
Үйл ажиллагааны бус үр дүн	(805.0)	(6,308.6)
Үйл ажиллагааны нийт үр дүн	668,235.3	(64,159.7)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,228,095.1	3,896,330.4
Тайлант оны үр дүн	668,235.3	(64,159.7)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		
Эцсийн үлдэгдэл	3,896,330.4	3,832,170.6
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,746,914.2	2,951,584.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,151,108.5	2,962,478.6
Үйл ажиллагааны ЦМГ	595,805.7	(10,893.9)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(478,650.0)	(33,736.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,625.2	152,780.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	152,780.8	108,150.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,625,975.4	2,994,750.3
Урсгал зардал	2,625,975.4	2,994,750.3
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,781,872.4	3,102,234.3
Улсын төсвөөс санхүүжих	1,945,605.5	2,401,387.6
Орон нутгийн төсвөөс санхүүжих	792,205.2	519,652.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,234.5	14,035.3
Туслах үйл ажиллагааны орлого	34,958.2	15,044.8
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	152,780.8	108,150.9

Гурав. Аудитын илрүүлэлт:

Залруулсан алдаа

Аудитаар 6,075.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Утасгүй интернэтийн үйлчилгээ, төхөөрөмжийн үлдэгдэл болох 6,075.1 мянган төгрөгийн өглөгийг данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 1,231.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,231.7 мянган төгрөгийн 1 зөрчил² илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.


Албан шаардлага

1. Санхүүгийн ажилтнуудад санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж ажилласан үндэслэлээр хууль тогтоомжид зааснаас 1,231.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



Гурав. Аудитын илрүүлэлт:

Залруулсан алдаа

Аудитаар 6,075.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Утасгүй интернэтийн үйлчилгээ, төхөөрөмжийн үлдэгдэл болох 6,075.1 мянган төгрөгийн өглөгийг данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 1,231.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,231.7 мянган төгрөгийн 1 зөрчил² илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Албан шаардлага

1. Санхүүгийн ажилтнуудад санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж ажилласан үндэслэлээр хууль тогтоомжид зааснаас 1,231.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Есөнбулаг сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль	1	6.1	1	6.1	1		1	6.1				
Дүн	1	6.1	1	6.1	1		1	6.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Есөнбулаг сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль	1	1.2			1	1.2	-	-	-	-	-	-
Дүн	1	1.2			1	1.2	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Онцгой байдлын газар	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	1	1.2	-	-	1	1.2	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			